



Соёлын биет бус өв



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization

ichcap

International Information and Networking Centre
for Intangible Cultural Heritage in the Asia-Pacific Region
under the auspices of UNESCO



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



Mongolian
National Commission
for UNESCO

A photograph of an elderly woman with grey hair tied in a bun, sitting on the ground and weaving palm leaves. She is wearing a pink sleeveless top and a blue and red patterned sarong. She is using a small tool to weave the leaves. The background shows a wooden structure and a large pile of green palm leaves.

СОЁЛЫН ТОГТВОРТОЙ

Соёлын биет бус өвийг (СББӨ) хадгалан хамгаалах тухай Конвенц нь “СББӨ бол соёлын олон төрөл байдлын эх булаг, тогтвортой хөгжлийн баталгаа болж байдаг учир үнэхээр чухал ач холбогдолтой” гэж хүлээн зөвшөөрч байгаа билээ.

Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх Хөтөлбөр бол эдийн засаг, нийгэм болон хүрээлэн буй орчин гэсэн 3 хүрээг хамарсан, Тогтвортой хөгжлийн 17 зорилт бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг багтааж байгаа юм. Эдгээр үйл ажиллагаанууд нь өөр хоорондоо дээд зэргээр уялдсан байхын сацуу бүхий л түвшинд хөгжлийн зам мөрийг тодорхойлж, хүний эрх, тэгш байдал болон тогтвортой байдлыг хангах зарчмуудыг бүрэн хүндэтгэн үзэж байгаа болно. СББӨ нь тогтвортой хөгжлийн гурван хүрээнд бүтээлч хувь нэмрээ оруулаад зогсохгүй Тогтвортой хөгжлийн хамгийн гол урьдчилсан нөхцөл болох нийгмийн энх тайван, аюулгүй байдлыг тогтоон бэхжүүлэхэд ч бас тус дэмээ үзүүлж байгаа билээ.

СББӨ-ийн хувь нэмрийг хүлээн зөвшөөрч бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн тулд түүний тогтвортой хөгжилд эзлэх байр суурийг хэрхэн илүү гүнзгий ойлгож болох вэ?



© Vice Ministerio de Cultura



© Vice Ministerio de Cultura

БИЕТ БУС ӨВ БА ХӨГЖИЛ

Translator: **Machlay Tuul**

Proofreader: **Urtnasan Norov**

Тогтвортой хөгжлийн эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчин гэсэн хүрээнүүд нь энх тайван ба аюулгүй байдлын үйл ажиллагааны тус тусдаа салангид салбар бус харин ч өөр хоорондоо дээд зэргээр харилцан уялдаатай юм. Энэхүү өргөн цар хүрээтэй зорилтуудыг хэрэгжүүлэхэд бүх хүрээг тэгш хамарсан цогцолбор бодлого явуулах шаардлагатай болдог байна. СББӨ нь хүрээ тус бүрт тогтвортой хөгжлийг хангахад үр бүтээлтэй тус хүргэж чадах юм. Дэлхий даяар хүмүүс хүн төрөлхтөний тусын тулд бидний хүсээд байгаа тэр ирээдүйг байнга ухааран ойлгож байх учиртай бөгөөд иймээс СББӨ-ийг хадгалж хамгаалах нь чухал ач холбогдолтой.

Нийгмийн хамтын хөгжил

Нийгмийн хамтын хөгжил нь хүнсний байнгын аюулгүй байдал, эрүүл мэндийн чанартай үйлчилгээ, баталгаат цэвэр ус болон эрүүл ахуйн нөхцлөөр хангагдах боломж, бүх нийтийн чанартай боловсрол, нийгмийн хамгааллын хамтын систем ба жендэрийн тэгш байдлыг хангахгүйгээр биелэх боломжгүй юм. Дээрх зорилтууд нь хамтын засаглал болон үнэт зүйлээ сонгох хүмүүсийн эрх чөлөөгөөр баталгаажин бэхжих шаардлагатай.

Хүний нийгэм нь бүхий л цаг хугацаа, орон зайд үндсэн эрэлт хэрэгцээ хийгээд нийгмийн асуудлуудаа шийдвэрлэхийн тулд байгалийн талаарх мэдлэг ба зан үйлүүд болон нийгмийн ёс заншлууд зэргийг багтаасан СББӨ-ийг хөгжүүлэхийн сацуу даган мөрдөж ирсэн юм. Уламжлалт ардын эмнэлгийн арга ухаан, хоолны соёл, ус хэрэглэх арга ухаан, олон нийтийн уулзалт цуглаан, баяр ёслолууд болон уламжлалт мэдлэг арга ухааныг өвлөн уламжлах тогтолцоонууд нь олон түмний оролцоотой хамтын нийгмийг хөгжүүлэхэд маш чухал үүрэгтэй.

СББӨ нь хүнсний аюулгүй байдлыг хангахад амин чухал үүрэгтэй. Уламжлалт хоол унд хийх арга ухаан болон газар тариалан эрхлэх, мал маллах, загасчлах, ан гөрөө хийх, хоол хүнс бэлтгэх, хадгалах нутаг нутгийн уламжлалт мэдлэг, арга ухааны тогтолцоонууд хоол хүнсийг болон хооллолтын аюулгүй байдлыг хангахад их хувь нэмэр оруулж чадах юм. Нутаг нутгийн бүлэг хамт олон нь өөрсдийн онцлог бүхий ахуй

болоод хүрээлэн буй орчиндоо бүх талаас нь цогцоор хандаж амьдрах явцдаа их хэмжээний уламжлалт мэдлэг, арга ухааныг хуримтлуулж иржээ.

Тэд тэрхүү арга ухаан, техникийг байгалийн болон таримал ургамал, үр тариа хийгээд мал, амьтны гаралтай түүхий эдийн маш олон зүйлийг ашиглаж хэрэглэх явцдаа бий болгон хөгжүүлж ирсэн юм. Байгалийн чийглэг, хойт зүгийн сэрүүн эсвэл хуурай, зөөлөн нөхцөл дэх өөрсдийн газар нутаг, хүрээлэн буй байгаль орчны байдалд нийцсэн олон янзын бөгөөд мөн тэдгээрийн өөрчлөлтөд дасан зохицсон хоол хүнс хийх арга ухаан, тэрчлэн хоол хүнс боловсруулах, хадгалах, нөөцлөх системийг хүмүүс бас хөгжүүлж ирсэн билээ. Дэлхий даяар асар олон гэр бүл хөрсний шим тэжээлийг өсөн нэмэгдүүлэхийн хамт янз бүрийн хоол хүнсээр хангаж, шаардлагатай хоол тэжээл, эрүүл мэндийг хүмүүст бэлэглэж буй газар тариалангаас хамааралтай байдаг. Газар тариалангийн эдгээр тогтолцоонуудыг тасралтгүй хөгжүүлэн сайжруулж байх нь дэлхий дахинд хоол хүнсний хүрэлцээ, аюулгүй байдал болон олон хүн, хамт олныг хоол тэжээлээр хангахад чухал ач холбогдолтой

Эрүүл мэндийг сахих уламжлалт ёс заншлууд нь хүн бүрийн сайн сайхан аж амьдрал хийгээд эрүүл мэндийн чанартай үйлчилгээг бий болгоход хувь нэмрээ оруулах боломжтой. Дэлхий дахинд хүмүүс, бүлэг хамт олнууд нь нутаг усныхаа байгалийн эх үүсвэрт түшиглэн, эрүүл мэндийг сахин хамгаалахтай холбоотой олон төрлийн мэдлэг, арга ухааныг хөгжүүлсээр ирсэн бөгөөд үр ашигтай, хэрэглэж болохуйц тийм эмчилгээ, сувилгааны аргуудыг хэрэглэсээр байна. Тухайлбал, эмийн ургамлаар мэргэшсэн ардын эм бариачид бол олон мянган жилийн турш хүмүүст эмчилгээ, сувилгаа хийдэг гол хүмүүс байсаар ирсэн билээ. Эмийн ургамлыг хэрэглэхтэй холбоотой тэдний мэдлэг, арга ухаан нь өвчтнүүдийг анагаах, эмчлэх энгийн уламжлалт арга туршлагаас үүдэлтэй. Жишээ нь, Танзанийн Танга дүүрэгт ардын домч нар, тодруулбал эмийн ургамлын мэргэжилтнүүд, эх барих болон сэтгэл мэдрэл эмчлэх уламжлалт арга ухааны мэргэжилтнүүд сэтгэл мэдрэлийн хийгээд биеийн өвчин эмгэгийг анагаах талаар тусгай мэдлэг, арга ухаантай юм. Тийм эмчилгээ нь эм тарианы хүрэлцээ муу байдаг алслагдсан нутагт хүртээмжтэй бас боломжтой юм.



© UNESCO / Isaack Omoro 2011



© UNESCO / Isaack Omoro 2011

Хоол хүнс нь баяр ёслолын нэг чухал хэсэг төдийгүй хүмүүст өөрсдийн онцлог дүр төрхөө таньж илэрхийлэх, хамт олондоо багтаж хамт байгаа гэсэн сэтгэл бахархлыг төрүүлж байдаг юм.



Дэлхий даяар асар олон гэр бүл хөрсний шим тэжээлийг өсгөн нэмэгдүүлэхийн хамт янз бүрийн хоол хүнсээр хангаж, шаардлагатай хоол тэжээл, эрүүл мэндийг хүмүүст бэлэглэж буй газар тариалангаас хамааралтай байдаг.

Эмчилгээ, сувилгааны энэ мэт арга ухааныг хүлээн зөвшөөрч, хүндэтгэлтэй хандахын хамт улам боловсронгуй болгох явдал чухал байна. Бас тэр арга ухааныг эрүүл мэндийн үйлчилгээ хүмүүст хүрэлцээтэй байгаа газарт ч залуу үеийнхэнд өвлөн уламжлуулах ажил хийвэл зохилтой. Эрүүл мэндийн бусад үйлчилгээ боломжтой газарт оюуны онцлог үнэт зүйлс агуулсан, нийгэм соёлын хүрээнд баттай төлөвшсөн уламжлалт мэдлэг, арга ухаан нь нэмэлт ач тустайгаас гадна хүмүүсийн сонголтыг илүү өргөн болгон тэлдэг юм.

Ус хэрэглэхтэй холбоотой уламжлалт арга ухаан, ёс заншлууд нь цэвэр усыг адил тэгш, байнга хэрэглэхэд бас хувь нэмрээ оруулах боломжтой ба энэ нь хөдөө аж ахуйн болон бусад ахуйн хэрэглээний усыг хэрэглэхэд хамаарна. Түүхийн бүхий л туршид орон нутгийн хүмүүс, бүлэг хамт олнууд нь тэдний гүн гүнзгий итгэл үнэмшил, уламжлалд түшиглэсэн цэвэр усыг байнга зохистой хэрэглэх арга ухааныг бий болгож чадахаа нотлон харуулсан билээ. Тэрчлэн бүгдээрээ цэвэр ус хэрэглэж болох боломжийг ч нотлон харуулсаар байна. Тухайлбал, Мексикийн Чиапас, Сан Кристобал Дэ Лас Касас дахь усны хэрэглээний аргууд нь Маяачуудын тахилгат газар нутгийн тухай шүтлэг бишрэл, ойлголтууд, түүнтэй холбоотой соёлын өв уламжлалаас улбаатай юм. Маяачууд нь хүн усны эргэлтийн салшгүй нэг хэсгийг бүрдүүлж, өөрийн биеийн шингэнээр дамжуулан усны нөөц баялгийг зогсолтгүй сэргээж эргэлтэд ороход нь хувь нэмрээ оруулдаг гэдэгт итгэдэг байв. Тиймээс усыг хэрэглээний зүйл гэхээс илүүтэй хамт олны бүгдийнх нь нөөц баялаг гэж үздэг бөгөөд харин усаар хангаж байх зохион байгуулалт нь бүхий л хамт олны үүрэг хариуцлага гэж үздэг байв. Ихэнх хүмүүс, хамт олны хувьд ус хэрэглэх дээрх арга ухаан, тогтолцоо нь цэвэр ус хэрэглэх цорын ганц боломж нь байсан агаад тийм учраас тэрхүү арга ухаанаа хойч үедээ өвлүүлэн уламжлах нь амин чухал байсан юм. Хүмүүс, хамт олон гаднаас, холоос ус хэрэглэж түүнээс хамаарах хамаарлыг багасгадаг учир уламжлалт тогтолцооны ач холбогдол хэвээр үлдсэн бөгөөд эмзэг дорой гэр бүлүүдэд ус хэрэглэх илүү боломжийг олгосон хэвээр байна. Усны нөөцийг хэрэглэх тогтолцооны олон төрлийн арга, үнэт зүйлсийг хүлээн зөвшөөрч хүндэтгэн үзэх, тэдгээрийг улам боловсронгуй болгон, өвлөн уламжлуулж байх явдал нь устай холбоотой хүрээлэн

буй орчны болоод хөгжлийн зорилтуудыг шийдвэрлэхийн тулд зохистой шийдлүүд гаргаж байх түлхүүр нь юм.

СББӨ нь боловсролын агуулга, арга зүйн амьд жишээг үзүүлж байна. Хүмүүсийн бүлэг хамт олнууд нь ялангуяа өөрсдийн байгалийн болон нийгмийн орчинтой холбоотой мэдлэг, амьдралын дадал туршлага, өрсөлдөх чадваруудаа боловсронгуй болгон эрэмблэж, ирээдүй хойч үедээ өвлөн уламжлах арга замуудыг хайн олж хэрэгжүүлсээр ирсэн билээ. Албан ёсны боловсролын тогтолцоо үйлчилж буй улс орнууд ч гэсэн уламжлалт мэдлэг хийгээд тэдгээрийг өвлөн уламжлах уламжлалт олон арга ухааныг өнөөдөр ч идэвхтэй хэрэглэсээр байна. Тэдгээр уламжлалт мэдлэг, арга ухаан нь мэргэжлийн олон хичээл сургалт болон салбаруудыг хамарч байна. Сансар судлал, физикээс эхлээд анагаах ухаан болон байгалийн нөөцийн тогтвортой хэрэглээ хүртэл, хүний амьдралаас эхлээд зөрчил мөргөлдөөн, хурцадмал байдлыг шийдвэрлэх хүртэл, нийгэмд эзлэх өөрийн болон бусдын байр суурийг ойлгохоос эхлээд хамтын дурсамж, ой санамжийг бий болгож хуримтлуулах хүртэл, уран барилгын ухаанаас материал судлах шинжлэх ухаан хүртэл гэх зэргээр үргэлжлүүлж болно. Чанартай боловсролыг хүн болгонд олгох явцад залуу үеийнхнийг соёлын онцлог, бусдаас ялгарах дүр төрхийг нь бий болгож байгаа тэрхүү өв сангаас нь холдуулж хөндийрүүлэхгүй байх ёстой. Тиймээс бүх нийтэд чанартай боловсрол олгох үйлс нь СББӨ-ийн бий болгосон их нөөц баялгыг хүлээн зөвшөөрөх учиртай бөгөөд дор дурдсан арга замаар түүний боловсрол, хүмүүжлийн чадавх, боломжийн үр шимийг хүртэх ёстой юм. Тухайлбал, нэг талаас холбогдох бүхий л мэргэжлийн хичээлүүдийн хөтөлбөрүүдийн агуулгад тэр нөөц баялгийг аль болох бүрэн дүүрэн тусгах, нөгөө талаас боловсролын тогтолцоон дотор СББӨ-ийг өвлөн уламжлах уламжлалт үлгэр загвар, арга барилын боломжийг үр ашигтай хэрэглэх арга замууд байгаа билээ.

СББӨ нь нийгмийн эв нэгдэл болон хамтын оролцоог бэхжүүлэхэд тус дэм үзүүлэх боломжтой. Нийгмийн ёс заншлууд, зан үйл болон баяр ёслолууд хүмүүс, хамт олон бүлгүүдийн амьдралыг цогцлоон хөглөх агаад тэд нар хамтран оролцож бүтээх аргаар нийгмийн амьдралыг бэхжүүлэхэд нь чухал үүрэг гүйцэтгэж чадна. Тухайлбал, хөгжим, бүжиг, гар урлалыг багтаасан Фрево хэмээх Бразилийн урлаг нь Католик баярын өмнө болдог шашны карнавал наадмын үеэр нийгмийн бүхий л давхаргын хүмүүсийг баясан цэнгүүлэхээр хуран цуглуулдаг юм. Фрево наадам нь Ресифегийн оршин суугчдын хамтын өв бөгөөд өөрсдийн бусдаас ялгарах онцлог дүр төрхөө илэрхийлэх, өв уламжлалаа үргэлжлүүлэх гэсэн тэдний сэтгэлийг бадраах, хүйс, арьс өнгө, нийгмийн гарал угсаа, нутаг ус үл харгалзан хамт олны үнэт зүйлсээ улам бататгах боломжийг бүрдүүлдэг юм. Гарал угсааны хувьд янз бүрийн хүмүүс хамтдаа Фрево хөгжмийн хэмнэлд бүжиглэн цэнгэдэг. Цомхон уулзалт цуглаанаас эхлээд олныг хамарсан томоохон баяр ёслолууд зэрэг маш олон ёс заншил нь тэрхүү ёс заншлыг дагаж мөрддөг, хүндэтгэдэг хүмүүсийн нийтлэг онцлог дүр төрхийг нь товойлгон харуулж,

нийгмийн хэлхээ холбоо, хүмүүс, хамт олны эв нэгдлийг бэхжүүлж байдаг аж.

СББӨ нь хүйсийн үүрэг, дүр төрхийг бий болгож өвлөн уламжлах тал дээр шийдвэрлэх ач холбогдолтой бөгөөд жендэрийн тэгш байдлыг хангахад чухал үүрэгтэй. СББӨ-өөр уламжлан хамт олнууд хүйсийн үнэт зүйлс, хэм хэмжээ, хүсэл тэмүүлээ өвлөн дамжуулж, хамт олны гишүүдийн хүйсийн өвөрмөц дүр төрх төлөвшин тогтож байдаг билээ. Түүгээр зогсохгүй өвийн тухайн илэрхийлэлд хамрагдах, оролцох гишүүдийн асуудал тэрхүү хүйсийн хэм хэмжээгээр тодорхойлогдож байдаг. Жишээлбэл, уламжлалт гар урлал нь голдуу тодорхой хүйсийн хүмүүстэй холбоотой хөдөлмөрийн хуваарьтай байдаг бол тайз дэлгэцийн урлаг нь хүйсийн хүсэл тэмүүлэл, үүргээ нийтэд чөлөөтэй илэрхийлэх давуу талтай юм. СББӨ нь нийгэм, хүрээлэн буй орчны өөрчлөлтүүдийг дагаж хувьсан өөрчлөгдөж, даган зохицож буйтай зэрэгцээд хүйсийн үүрэг ч мөн өөрчлөгдөж байдаг. Хамт олнуудын хүйсийн харилцаа нь гишүүдийн байнгын харилцан зөвшилцлөөр зохицуулагдаж байдаг бөгөөд тиймээс хүйсээр ялгаварлан гадуурхах явдлаас сэргийлсэн



Хүмүүс, хамт олнууд, ялангуяа тэдний байгалийн болон нийгмийн хүрээлэн буй орчинтой холбогдолтой өөрсдийн мэдлэг, амьдралын дадал туршилага, өрсөлдөх чадваруудаа боловсронгуй болгон эрэмбэлж, ирээдүй хойч үедээ өвлөн уламжлах арга замуудыг үргэлж эрж хайн олж, түүнийгээ хэрэгжүүлсээр ирсэн билээ.

боломжуудыг нээж СББӨ-ийн ёс заншил, зан үйлүүдээр дамжуулан хүйсийн тэгш байдлыг хангахад чиглэсэн алхмуудыг хийх нь зүйтэй байна. СББӨ нь хүйсийн асуудлаар гишүүд өөр өөр үзэл бодолтой, олон соёлын орчин бүхий хамт олны дотор итгэл үнэмшил төрүүлэх, хүлцэл тэвчээртэй байх явдлыг төлөвшүүлэх, мөн хүйсийн тэгш байдлыг хэрхэн хангах чиглэлээр харилцан ойлголцол, нийтлэг орчин бүрдүүлэхэд маш чухал үүрэг гүйцэтгэж чадна.

Хүрээлэн буй орчны тогтвортой байдал

Хүрээлэн буй орчны тогтвортой байдал нь уур амьсгалыг тогтворжуулах, байгалийн баялгийн зүй зохист тогтвортой хэрэглээг удирдан зохицуулах, биологийн олон төрөл байдлыг хадгалан хамгаалахыг шаардаж байдаг юм. Энэ нь эргээд уур амьсгалын өөрчлөлт, байгалийн гамшиг, агаар мандлын хүрээлэн буй орчин болон байгалийн нөөц баялгийн хязгаарлагдмал байдлын талаарх шинжлэх ухааны ахиж дэвшсэн ойлголт, хамтын мэдлэгээс хамааралтай юм. Уур амьсгалын өөрчлөлт ба байгалийн гамшигтай нүүр тулгараад буй эмзэг ядуу хүмүүст уян хатнаар зохицон, сөрж амьдрах чадвар суулган бэхжүүлэх нь тэдний хүмүүнлэгийн болоод нийгэм-эдийн засгийн гарз хохирлыг багасгахад чухал ач холбогдолтой. Өнөөдөр хүрээлэн буй орчныг тогтвортой байлгах үйлсэд СББӨ-ийн оруулж буй хувь нэмрийг биологийн олон төрөл зүйлийг хадгалж хамгаалах, байгалийн баялгийг тогтвортой удирдлагаар хангах, байгалийн гамшгаас сэргийлэхэд бэлтгэх арга хэмжээ авах зэрэг үйл ажиллагааны олон салбарт хэдийнээ хүлээн зөвшөөрсөн байна.

Амьд өв болохынхоо хувьд хүрээлэн буй орчинтой холбоотой СББӨ-ийн цогц мэдлэг, үнэт зүйлс, ёс заншлууд нь шаардлагатай тохиолдолд байгалийн баялгийг илүү тогтвортой зүй зохистой ашиглах чиглэлээр хувьсан өөрчлөгдөх, дасан зохицох чадвартай, байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй бэрхшээлүүдтэй тулгарахад бэлтгэлтэй байхад нь хамт олон, хүмүүст тус болдог юм.



© 2010 by Acervo PCR



© 2010 by Acervo PCR



© 2006 by Acervo PCR

Нийгмийн ёс заншлууд, зан үйл болон баяр ёслолууд хүмүүс, хамт олон бүлгүүдийн амьдралыг бүтээн хөглөх агаад тэд нар хамтран оролцож бүтээх аргаар нийгмийн амьдралыг бэхжүүлэхэд нь чухал үүрэг гүйцэтгэж чадна.

СББӨ нь биологийн олон төрөл зүйлсийг хамгаалахад тусалдаг. Уугуул иргэд, нутгийн хүмүүс, бүлэг хамт олноуд биологийн олон төрөл зүйлийг хадгалан хамгаалах, зүй зохистой байнга тогтвортой ашиглахад голлох үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, Кени дэх Кикиу бүсгүйчүүд хүнсний ургамал тариалах, үр хадгалж нөөцлөхөд голлон оролцдог. Уламжлал ёсоор бол бүсгүйчүүд олон төрлийн буурцгийг нэг л талбайд тарьж ургуулдаг байсан ба мөн олон төрлийн үрийг өвчин эмгэг тохиолдох болоод урьдаас тааж болохгүй цаг уурын гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлж нөөцөлдөг байжээ. Харин өнөөдөр тэдгээр үрийн нөөцүүд нь уугуул иргэдийн хувьд ургамлын талаарх мэдлэгийн үнэт баялаг өв сан болж байгаа бөгөөд олон арван жилийн туршид нэг талбайд ургамал тариалснаас үүдэлтэй газар тариалангийн генетикийн эх үүсвэрийн хомсдолд улс даяараа ороод байгаа энэ үед улам бүр үнэ цэнэтэй болсоор байна. Тариаланчид, малчид, загасчид болон уламжлалт эмч домч нар нь уугуул нутгийн мэдлэгийн бусад тээгчдийн нэгэн адил биологийн олон төрөл зүйлийг өвлөн уламжлагчид юм.

СББӨ нь хүрээлэн буй орчны тогтвортой байдалд хувь нэмэр оруулах боломжтой.

Дэлхий даяар хүний үйл ажиллагаа нь байгалийн баялгийг зүй бусаар улам ихээр ашиглаж, хэрэглээний үзлийг шүтсээр байхад уугуул нутгийн маш олон хамт олон байгальтай эвлэлдэн зохицож, хүрээлэн буй орчиндоо хүндэтгэл бишрэлтэйгээр хандсан тийм амьдралын хэв маяг, ёс заншлыг хөгжүүлсээр байгаа билээ. Жишээлбэл, Самоагийн нарийн ур хийцтэй сүрлэн сүлжмэл дэвсгэрийг баяр ёслолын үйл ажиллагааны үеэр ёслол хийх эсхүл хүмүүс баярын жагсаалд оролцохын тулд төлбөр хийх мөнгөн тэмдэгтийн хэлбэрээр хэрэглэдэг байна. Цаг хугацааны явцад маш олон экологийн уламжлалт мэдлэг нь сүлжмэлийн гол материал болох дал модтой төстэй олон тушман модыг тариалах гэх мэт нэхэх, сүлжих үйл бүтээлтэй холбогдож ирсэн байдаг. Энэхүү мэдлэг нь Самоачуудад хүрээлэн буй орчноо хадгалан хамгаалахад нь тусалдаг юм. Дэлхий даяар их хэмжээгээр хэрэглэж байгаа хуванцар болон хүрээлэн буй орчинд гэм халтай бусад бүтээгдэхүүнүүдийг бодвол ургамлаар хийсэн нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн нь ургамлаа тариалахаас эхлээд түүнийг хураах, хэрэглэх, нэхмэл сүлжмэл хийх, эцэст нь хог болгон хаях хүртэл харьцангуй бага хугацаа зарах ба тэдгээр нь байгальдаа амархан шингэж уусан алга болдог юм.

Нутгийн уугуул иргэд цаг хугацааны явцад хуримтлуулж ирсэн байгальтай холбоотой мэдлэг, ёс заншлууд нь байгалийн баялгийг байнга зүй зохистой ашиглах болон цаг уурын өөрчлөлтийн сөрөг нөлөөг багасгахад хэрэг болсоор байдаг юм. Тиймээс СББӨ нь биологийн олон төрөл зүйлийг хадгалж хамгаалахад болон хүрээлэн буй орчны тогтвортой байдалд чухал хувь нэмэр оруулах боломжтой.



© Steven Percival



Дэлхий даяар олон тооны бүлэг хамт олон байгальтай эвлэлдэн зохицож, хүрээлэн буй орчиндоо хүндэтгэл биширэлтэйгээр хандсан тийм амьдралын хэв маяг, ёс заншлыг хөгжүүлсээр байгаа билээ.

© Steven Percival



© Dirk Van Hove, Gemeente Koksijde Paardenvissers_02 2007



Байгальтай холбоотой уугуул нутгийн мэдлэг, ёс заншлууд тогтвортой хүрээлэн буй орчны судалгаанд чухал хувь нэмэр оруулах боломжтой. Тухайлбал, стратегийн чухал мэдээлэлтэй байдаг уламжлалт загасчид нь далайн биологийн олон төрөл зүйлд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд туслах боломжтой. Тэдгээр загасчид жилийн улирлуудад дасан зохицсон загасны экологи, зан авир, үйлдэл, тэдний нүүдэл, орчин, загас агнуур болон загасчлахуйн ёс заншлуудын талаар шалгарсан маш нарийн мэдлэг мэдээллийг хуримтлуулсан байдаг. Тэдгээр тов тодорхой, олон төрлийн, байнга баяжиж байдаг мэдлэг бол далай тэнгисийн биологийн олон төрлийг хадгалж хамгаалах, нөхөн сэргээж байхад бусад шинжлэх ухааны судалгаануудыг орлон нөхөж, тус дэм үзүүлэх боломжтой. Нутгийн иргэд, хамт олон болон эрдэмтэн судлаачид хоорондын олон улсын хамтын ажиллагаа, тэдний хамтын ажиллагааны тэргүүн туршлага, арга зүй нь ойн болон биологийн олон төрөл зүйлийг хадгалан хамгаалах, байгалийн баялгийн менежмент зэрэг олон чиглэлээр хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангахад гайхалтай хувь нэмэр оруулах боломжтой.

Мэдлэг ба даван туулж дасан зохицох стратеги нь байгалийн аюул гамшиг болон уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамт олонд түшиглэн, уян хатан байж, даван туулах чадварыг төлөвшүүлэхэд ихэнх тохиолдолд үндэс суурь нь болж өгдөг байна. Цаг уурын эмзэг хүнд хэцүү орчинд амьдардаг уугуул нутгийн хамт олноуд уур амьсгалын өөрчлөлт болон байгалийн аюул гамшигт хамгийн түрүүнд өртөх эрсдэлтэй. Тэдний экологийн тухай ойлголт, хүрээлэн буй орчин, биологийн олон төрөл зүйлийг хадгалан хамгаалах чадвар, дэг ёс, байгалийн баялгийн менежментийн тогтолцоо, байгалийн аюул гамшиг, цаг агаарыг урьдчилан тооцоолох тогтолцоо зэрэг байгаль, цаг ууртай холбоотой мэдлэг, ёс заншлууд нь байгаль, хүрээлэн буй орчны аюул эрсдлийг даван туулах тэдний стратеги зорилтын баялаг өв санг бүрдүүлдэг юм. Хувьсан өөрчлөгдөж буй нөхцөл байдалд үргэлж боловсронгуй болж, дасан зохицож байдаг тэдгээр мэдлэг, ёс заншлууд нь уугуул нутгийн хамт олноудад байгалийн аюул гамшигтай холбоотой эрсдлийг багасгахад нь болон хэрэв шаардлагатай бол өөрчлөн байгуулах, уур амьсгалын өөрчлөлтөд зохицох зэрэгт нь их тус болж байдаг цаг хугацааны явцад шалгарч өвлөн ирсэн арга хэрэгслүүд юм.

Эдийн засгийн хамтын хөгжил

Тогтвортой хөгжил нь бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хэрэглээний тогтвортой загварт суурилсан байнгын шударга, хамтын эдийн засгийн өсөлтөөс хамааралтай. Хамтын эдийн засгийн хөгжил нь ядуу хэмээн тодорхойлдог бүлэгт анхаарлаа хандуулаад зогсохгүй эрсдэлтэй, аз туршсан амьдрал ахуй бүхий эмзэг бүлэг, хүмүүс, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн оролцож чаддаггүй, гадуурхагдсан хүмүүст ч анхаарлаа хандуулах учиртай. Энэ бүхэн нь үр бүтээлтэй, зүй зохистой, боломжийн хөдөлмөр эрхлэлт, мөн ядуурал, тэгш бус байдлын бууралт, нүүрсгөрөгч хийн доогуур үзүүлэлт, эдийн засгийн үр ашигтай өсөлт болон нийгмийн халамжийн баталгаа зэргийг шаардана. СББӨ нь энэхүү өөрчлөн хувиргагч хөгжилд чухал үнэт эх суурь нь болж өгдөг. СББӨ нь мөнгөний болон мөнгөний бус үнэ цэнэ бүхий эдийн засгийн аль алиных нь хувьд хөгжлийн хөдөлгөгч хүч болж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг олон төрөл янз болгож, ялангуяа орон нутгийн эдийн засгийг бэхжүүлэн хүчтэй болгож байдаг. Мөн түүнчлэн амьд өв болохынхоо хувьд СББӨ нь өөрчлөлтийн үед инновацийн чухал эх үүсвэрийг бүрдүүлж, орон нутгийн болоод олон улсын түвшинд хамтын эдийн засгийг бий болгоход ач тусаа өгөх боломжтой.

СББӨ нь бүлэг, хамт олнуудын тогтвортой амжиргаанд голлох үүрэгтэй. Үе үеийн хүмүүсээр дамжин уламжлагдан улам бүр сайжирч ирсэн уугуул нутгийн мэдлэг, чадвар, арга ухаан нь олон хүмүүсийн амжиргааны нь арга хэрэгсэл болж байдаг. Тухайлбал Эстонийн гэр бүлийн фермерүүд хонь малаа өсгөж ноосыг нь боловсруулахдаа байгаль дэлхий болон нутгийнхны ардын мэдлэг арга ухаантай нягт уялдуулж хийдэг юм. Энэхүү амьдралын хэв маяг нь тэдний амжиргааг залгуулж, онцлог дүр төрхийг нь бүрдүүлдэг. Тэд нэхмэлчдэд зориулж ноосоо ээрч утас бэлтгэнэ. Эсгий, сүлжмэл бүтээгдэхүүн хийхээс гадна лаа, саванг хонины өөхөөр хийнэ. Иймэрхүү амжиргааны арга ухаан нь тухайн хамт олны сайн сайхан аж амьдралд чухал төдийгүй нутгийн түвшинд ядуурлыг бууруулах, түүнээс хамгаалах гол арга болж байна. Энэ нь уугуул нутгийн газар тариалангийн арга ухаан, байгалийн баялгийн менежментийн тогтолцоо зэрэг бусад олон арга ухааны хувьд адилхан юм.



© 2008 by Bank Museum Institute, Pekalongan / Gaura Marcaniladipura



© 2008 by Bank Museum Institute, Pekalongan / Gaura Marcaniladipura

СББӨ нь ядуу, эмзэг бүлгийн хүмүүс, хувь хүн, ер нь хүмүүст ашиг орлого, боломжийн ажлын байрыг бий болгоно. Тухайлбал, уламжлалт гар урлал нь гол төлөв бүлэг, хамт олон, хувь хүмүүсийн бэлэн мөнгөний эсхүл бараа солилцооны орлогын үндсэн эх үүсвэр болдог ба тэгэхгүй тохиолдолд тэдгээр хүмүүс эдийн засгийн тогтолцоонд оролцож чадахгүй гадна нь үлдэх болно. Энэ нь зөвхөн гар урчууд, тэдний гэр бүлийнхэнд ашиг орлого өгөөд зогсохгүй бүтээгдэхүүний тээвэрлэлт, борлуулалт эсхүл бүтээгдэхүүн хийх түүхий эдийг цуглуулж бэлтгэхэд оролцсон бүх хүмүүст үр ашгаа өгнө. Энэхүү үйл ажиллагаанууд нь гол төлөв гэр бүлийн, хамт олны хүрээнд хийгдэх бөгөөд

*СББӨ бүлэг, хамт олнуудын
тогтвортой амжиргаанд
голлох үүрэгтэй.
СББӨ нь ядуу, эмзэг
бүлгийн хүмүүс, хувь хүн,
ер нь хүмүүст ашиг орлого,
боломжийн ажлын байрыг
бий болгоно.*



© 2008 by Batik Museum Institute, Pekalongan / Gaura Mancasariladipura

боломжийн ажлын байрыг хадгалж, хөдөлмөр эрхлэлтийг бий болгон нэмэгдүүлж байдаг юм. Тэдгээр нь ажлын байр хадгалж, хамтач уур амьсгалыг төрүүлж, хамт олны өөрийн гэсэн онцлог дүр төрхийг товойлгон илтгэн харуулахтай нягт холбогдох учир нэр хүндтэй ажилд тооцогдоно. Тайз дэлгэцийн урлаг, баяр ёслолын арга хэмжээнүүд, СББӨ-ийн өөр бусад зүйл нь хамт олны гишүүд, нэн ялангуяа эмэгтэйчүүд ба залуучуудыг эдийн засгийг хөгжүүлэхэд өргөнөөр хамруулж байдаг билээ.

СББӨ нь амьд өв болохынхоо хувьд хөгжлийн төлөөх инновацийн гол эх ундарга болох боломжтой. Бүлэг, хамт олнууд өөрчлөлттэй тулгарахдаа үргэлж шинэ санааг эрэлхийлж байдаг. СББӨ нь орон нутгийн болоод олон улсын түвшинд өөрчлөлтийн шинжтэй хөгжлийг авчрах стратегийн ач холбогдолтой нөөц эх үүсвэр юм. Шинэ материалууд хуучны хэрэгцээ шаардлагыг хангахын тулд дасан зохицож болно. Тухайлбал, хэрэв тодорхой түүхий эд ховор юм уу олдох боломжгүй тохиолдолд хуучны мэдлэг чадвар шинэ сорилтуудыг даван туулах боломж олгож болох юм. Тодруулбал, цаг хугацааны шалгуурыг даван шалгарч ирсэн соёлын өвлөн уламжлах тогтолцоонууд нь мэдээлэл харилцааны шинэ технологид дасан зохицож буйг энд дурдаж болно.

Хамт олнууд СББӨ-тэй холбоотой аялал жуулчлалын үйл ажиллагаанаас ашиг тус хүртэх боломжтой. Уламжлал, ёс заншил, баяр ёслол, тайз дэлгэцийн уламжлалт урлаг, гар

урлалтай холбоотой ур чадвар, СББӨ-ийн бусад төрөл зүйлүүдийг олноор нээн илрүүлж байгаа явдал бол үндэсний, бүс нутгийн, цаашлаад олон улсын түвшинд жуулчдыг татах хүчтэй хөшүүрэг юм. Аялал жуулчлалын энэ үйл ажиллагаанууд нь ашиг орлого оруулж, ажлын байр бий болгохын сацуу хамт олны гишүүн болж байгаагаараа бахархах сэтгэлийг төрүүлж байдаг аж. Энэ нь амьд өв болон тухайн СББӨ-тэй холбоотой ёс зүй ба хариуцлагын зарчмыг хүмүүс хүндэтгэдэг болгоход нөлөөлдөг байна. Гэвч хэрэв аялал жуулчлал нь өвийн зүйлийг хамгаалж, хүндэтгэхгүй байх аваас түүнийг эрсдэлд оруулж болох юм. Нэг жишээ авахад, хэт ашиг хонжоо хайсан арилжааны үйл ажиллагаанууд хамт олны хувьд хамаатай өвийн утга учир, зорилго, нөлөөг нь өөрчилж үгүй хийж болох юм. Тиймээс аялал жуулчлалын үйл ажиллагаанууд төр, засаг, олон нийт, эсвэл хувийн хэвшлийн аль нь ч хариуцаж байсан ялгаагүй СББӨ-ийг болон холбогдох хамт олны эрх, хүсэл эрмэлзлийг хамгаалж, хөгжүүлэх талаар туйлын хүндэтгэлтэй хандах нь чухал. Холбогдох хамт олон нь өөрсдийн өвтэй холбогдолтой аливаа аялал жуулчлалын үйл ажиллагааны ашиг тусыг нь хүртдэг гол эзэд нь байх ёстой бөгөөд өвийнхөө зүйлийг ашиглах, удирдан зохицуулах тухайд голлох үүрэгтэй оролцох учиртай. Жуулчид болон аялал жуулчлалд оролцогчдын үйлдэл, биеэ авч явах ухамсар ойлголтыг нь залж нөлөөлөх замаар ёс зүйтэй, СББӨ-ийг хүндэтгэдэг аялал жуулчлал хөгжиж, өвийн зүйлд ямарваа нэг сөрөг нөлөө үзүүлэхээс зайлсхийж чадах билээ.

Энх тайван ба аюулгүй байдал

Зөрчил, мөргөлдөөн, ялгаварлан гадуурхах болон хүчирхийллийн бүхий л хэлбэрээс ангид чөлөөтэй байх гэх мэт энх тайван аюулгүй аж төрж амьдрах явдал тогтвортой хөгжлийн зайлшгүй нэг урьдчилсан нөхцөл юм. Дээр дурдсан зорилтуудыг биелүүлэхэд хүний эрхийг хүндэтгэхийн хамт шударга ёсны үр бүтээлтэй улс төрийн хамтын зөв шийдлүүд гаргаж байх тогтолцоо, зөрчил мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлж, шийдвэрлэж байх чадвартай тогтолцоо зэргийг төлөвшүүлэн бэхжүүлсэн байхыг шаардаж байдаг юм. Энх тайван, аюулгүй байдал нь нутгийн хүмүүс байгалийн баялгийг ашиглах, түүнд хяналт тавихад хэрхэн оролцож байгаагаас шалтгаалахын хамт ямар нэгэн ялгаварлал, гадуурхалгүйгээр газар эзэмших баталгаа гаргаж, эрхийг нь олгохоос бас хамаарна.

СББӨ-ийн янз бүрийн ёс заншил, зан үйлүүд, төлөөллүүд, илэрхийллүүд нь энх тайван байдлыг бий болгож, бататган бэхжүүлж байдаг заяаны увидастай бөгөөд тийм учраас яриа хэлцэл хийж тохиролцох, харилцан ярилцаж ойлголцох явдлыг байнга хөхүүлэн дэмжиж дэлгэрүүлж байдаг билээ. СББӨ-ийг хамгаалж дэмжих үйл ажиллагаа нь өөрөө энх тайвныг тогтооход хувь нэмрээ оруулж чадах юм. СББӨ

ба түүнийг хамгаалж дэмжих үйл ажиллагаа нь хамтын оролцоо, энх тайвнаар зэрэгцэн амьдрах, маргааныг урьдчилан сэргийлж шийдвэрлэх, бат бэх аюулгүй байдал болон энх тайвныг тогтооход чиглэсэн соёлын шаардлагатай зорилтууд дэвшүүлж шийдвэрлэж байх бололцоог хамт олон, засаг төр, оролцогч бусад түнш, дэмжигчдэд олгож байдаг билээ.

СББӨ-ийн маш олон ёс заншлууд нь энх тайвныг хөхиүлэн дэмжих заяамал чанартай. 1236 онд Сундиата Кэйти хууль ёсны болгосон Мали улсын Манден хууль нь (Малигийн эзэн гүрний үндсэн хууль) үүний нэг жишээ юм. Энэ нь хүний эрхийн талаарх дэлхийн хамгийн анхны хуулиудын нэг бөгөөд янз янзын улс орон дахь нийгмийн энх амгалан байдал, хүний халдашгүй дархан байдал, боолчлолыг нэг мөсөн халах, үзэл бодлоо илэрхийлэх, худалдаа хийх эрх чөлөө гэх зэрэг үнэт зүйлсийг өмгөөлөн хамгаалсан байдаг. Анх хуулийг гарсан цагаас нь л аман зохиолын тасралтгүй уламжлан дамжуулж ирсэн өв гэж үзэж үг хэллэг, холбогдох зан үйлийг Малинкэ хүмүүс нэн хүндэтгэлтэйгээр хадгалсаар байна. Мали дахь Кангаба тосгонд дээр үед хүмүүс хуран цугларч хуралддаг байсан Түүхэн Чуулганыг дурсан тэмдэглэдэг баяр ёслолыг нутгийн захиргаа, үндэсний төв засаг захиргаа болон тэр тусмаа хууль зүйн эх сурвалж, энэрэл



хайр, энх тайван, ах дүүгийн ёсны захиас сургааль хэмээн түүнийг үздэг уламжлалт засаг захиргааныхан жил бүр зохион байгуулдаг юм. Дэлхий дахинд СББӨ-ийн маш олон илэрхийллүүд энх тайвны үнэ цэнийг хөхиүлэн дэмжиж, хадгалан хамгаалах манаанд зогсож байдаг билээ.

СББӨ нь зөрчил маргааныг урьдчилан сэргийлж шийдвэрлэхэд туслах боломжтой. Харилцан ярилцаж ойлголцох, зөрчил мөргөлдөөнийг зохицуулж шийдэх болон эе эвийг тогтоох талаарх нутгийн ёс заншлууд нь дэлхий дахинд улс орнуудын нийгмийн хөгжилд шийдвэрлэх үүрэгтэй байдаг. Нийгмийн болон хүрээлэн буй орчны онцлог нөхцөл байдалд тулгарсан асуудлуудыг шийдвэрлэх, нийгмийн орчин, байгалийн баялгаас хүртэх асуудлыг зохицуулахад туслах, хүмүүсийг эв найртай хамтран амьдрахад нөлөөлөх явцад олон зуунаар шалгарч өвлөгдөн ирсэн эдгээр тогтолцоонууд ард түмнийг албан ёсны бус уламжлал болсон байх бөгөөд маш сайн хөгжсөн байх нь элбэг. Тухайлбал, Испанийн Мурсиа болон Валенсия мужийн цөлөрхүү бүс нутгийн фермерүүд нь бүс нутагтаа алдартай хүнсний ногоо, жимс, цэцэг тарьж ургуулахад маш чухал ус түгээх болон усалгааны системийг эрхлэхтэй холбоотой үүссэн маргаанаа нийтийн шүүхээр шийдвэрлүүлдэг уламжлалтай. Мурсиагийн

тал нутгийн Мэргэдийн Зөвлөл болон Валенсиягийн тал нутгийн Усны Шүүх нь долоо хоногийн Пүрэв гараг бүр бусад иргэний шүүхэд ч хүчин төгөлдөр үйлчлэх, мэргэн зөв шийдвэр гаргахаар цуглаж уулзацгаадаг. Ардын Шүүхийн гишүүд нь фермерүүд байх бөгөөд ардчилсан зарчмаар сонгогдсон эсвэл олонх шууд дэвшүүлсэн тэд нар газар тариалан, усжуулалтын талаар нутгийн ардын зан заншилд тулгуурлан маргаантай заргыг таслан шийдвэрлэдэг байна. Иймэрхүү СББӨ-ийн нийтийн ёс заншил өнөөдөр ч хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа явдал холбогдох хүмүүс хүлээн авч болохуйц хамтын арга замаар маргаан зөрчлийг урьдаас сэргийлж шийдвэрлэн хамгаалж бэхжүүлэх, хамт олны чадавхийг бий болгоход гол хүчин зүйл юм.

СББӨ нь энх тайван ба аюулгүй байдлыг дахин сэргээн хамгаалахад хувь нэмэр оруулах боломжтой. Жишээлбэл энх амгалан, эе эвтэй байх зан үйл нь хувь хүмүүс, гэр бүл эсвэл хамт олон аль нь ч байлаа тэдний хоёр талын хооронд энх тайван, эе эвийг тогтоох нийгмийн их хүч нөлөөтэй. Энх амгалан, эе эвтэй байх зан үйл нь хүч үл хэрэглэх хүсэл зорилгыг бий болгох талаар хүмүүсийн харилцааг өөрчлөхөд билэгдлийн агуулгаар нөлөөлж болно. Тэдгээр нь хүмүүст нэг нэгэнтэйгээ харилцахад нь тусалж, үл



Харилцан ярилцаж ойлголцох, зөрчил мөргөлдөөнийг зохицуулж шийдэх болон эе эвийг тогтоох талаарх нутгийн ёс заншлууд нь дэлхий дахинд улс орнуудын нийгмийн хөгжилд шийдвэрлэх үүрэгтэй байдаг. Нийгмийн болон хүрээлэн буй орчны онцлог нөхцөл байдалд тулгарсан асуудлуудыг шийдвэрлэх, нийгмийн орчин, байгалийн баялгаас хүртэх асуудлыг зохицуулахад туслах, хүмүүсийг эв найртай хамтран амьдрахад нөлөөлөх явцад олон зуунаар шалгарч өвлөгдөн ирсэн эдгээр тогтолцоонууд албан ёсны бус уламжлал болсон байх бөгөөд маш сайн хөгжсөн байх нь элбэг.

ойлголцох, атаархаж мөчөөрхөх, үзэн ядах, хүчирхийлэх гэсэн санаа сэдэл, үйлдлийг тогтоон барьж, давж гарах хүч тэнхээг тэдэнд хайрладаг юм.

СББӨ-ийн хадгалалт хамгаалалт нь энх тайван, аюулгүй байдлыг тогтоон бэхжүүлж байх арга хэрэгсэл мөн. Хэрэв СББӨ-ийн зүйл нь хамтын оролцоог хангасан бол түүнтэй холбоотой хадгалж хамгаалах, дэмжих ажиллагаа нь уугуул иргэд, шилжиж ирэгсэд, дүрвэгсэд, цагаач иргэд, өөр өөр нас, хүйсийн хүмүүс, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон нийгмээс гадуурхагдсан хүмүүс зэргийг багтаагаад бүлэг, хамт олон, хувь хүмүүсийг нэг дор хамтад нь цуглуулах хүчтэй хөшүүрэг юм. Ардчилсан засаглал тогтоох, хүний эрхийг хүндэтгэхэд ийнхүү хувь нэмэр оруулахдаа СББӨ-ийг хамгаалж, хөхиүлэн дэмжих үйл ажиллагаа нь энх тайван, аюулгүй байдлыг

тогтоох хүчин зүйлүүд бий болох үйл явцыг дэмжиж байгаа болно. Ийм хүчин зүйлд олон үе дамжсан нийтлэг үнэт зүйлийг өвлөн уламжлах, хамтын онцлох дүр төрхөө илэрхийлэх бодол сэтгэлийг төрүүлэх, өөртэй хүндэтгэлтэй хандах, түүнчлэн бүтээлч эдийн засгийн шинэ боломжуудыг бий болгох зэрэг өргөн хүрээний хүчин зүйлүүдийг оруулж байна. Мөргөлдөөний дараах нөхцөл дэх хадгалж хамгаалах үйл ажиллагаа, мөн оролцогч талуудын урьд өмнөх сайн сайхан санамж, дурсамжийг дахин сэргээх төслийн хүрээнд уулзуулах боломжтой. СББӨ-ийг хадгалж хамгаалах үйл ажиллагаа бол соёл хоорондын харилцан яриа, биет бус амьд өвийг тойрсон соёлын олон төрөл зүйлийг хүндэтгэх үйлсээр дамжуулан эе эв, эвлэлдэн нэгдэх явдлыг хөхиүлэн дэмжиж, ингэснээр нийгмийн дотор энх тайван, аюулгүй байдлыг дахин сэргээх үр дүнтэй, тогтвортой арга замыг нээж байгаа болно.

Нутгийн уугуул иргэдийн цаг хугацааны явцад хуримтлуулж ирсэн байгальтай холбоотой мэдлэг, ёс заншлууд нь байгалийн баялгийг байнга зүй зохистой ашиглахад болон цаг уурын өөрчлөлтийн сөрөг үр нөлөөг багасгахад хэрэг болсоор байдаг юм. Тиймээс СББӨ нь биологийн олон төрөл зүйлийг хадгалж хамгаалахад болон хүрээлэн буй орчны тогтвортой байдалд чухал хувь нэмэр оруулах боломжтой.



© Tribunal de las Aguas de la Vega de Valencia

© Tribunal de las Aguas de la Vega de Valencia







Соёлын
биет
бус өв



The designations employed and the presentation of material throughout this publication do not imply the expression of any opinion whatsoever on the part of UNESCO concerning the legal status of any country, territory, city or area or of its authorities, or the delimitation of its frontiers or boundaries. The authors are responsible for the choice and the presentation of the facts contained in this book and for the opinions expressed therein, which are not necessarily those of UNESCO and do not commit the Organization.

The present translation has been prepared under the responsibility of the International Information and Networking Centre for Intangible Cultural Heritage in the Asia-Pacific Region under the auspices of UNESCO (ICHCAP) and Mongolian National Commission for UNESCO.



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization

ichcap

International Information and Networking Centre
for Intangible Cultural Heritage in the Asia-Pacific Region
under the auspices of UNESCO



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



Mongolian
National Commission
for UNESCO